



“БАГАЧУУД ХҮНС”
ОНӨААТҮГ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

СБД, ЧД-ийн ерөнхий боловсролын сургууль болон
сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлэх
хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
нээлттэй тендер

Тендер
шалгаруулалтын
дугаар:

БХОНӨААТҮГ/20240102029

Улаанбаатар хот 2024 он

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	3
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	4
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	4
11. Тендерийн иж бүрдэл	4
12. Тендерийн жишиг маягтууд	5
13. Хувилбарт санал	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	6
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	6
16. Чадавхын болон туршлагын шаардлага	8
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	8
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	9
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	9
20. Тендерийн валют	10
21. Тендер хүчинтэй байх хугацаа.....	10
22. Тендерийн баталгаа.....	11
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	11
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	11
25. Тендерийн талаар тодруулга авах	12
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	12
27. Тендерийг үнэлэх	12
28. Арифметик алдааг запруулах	12
29. Оролцогчид давуу эрх олгох	12
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	12
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	13
32. Тендерийг эрэмбэлэх.....	13

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	13
34.	Мэдэгдэл хүргүүлэх.....	13
35.	Гүйцэтгэлийн баталгаа	13
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	13

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн хүрээ	цар	1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг		1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж		1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем		1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
5. Авлига, сонирхлын зөрчлөөс байх	ашиг ангид	2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
		3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1- д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
		4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

- 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
 - 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогч**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
 - 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
 - 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
 - 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
 - 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
 - 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
 - 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
 - 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- Б.АГУУЛГА**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
- II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
- III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
- IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
- V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
- VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13. Тендерийн бүрдэл иж**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын туршлагын шаардлага** болон **18.1.** Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2.** Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3.** Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4.** Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт** **19.1.** Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

- 24. Тендерийн баталгаа** 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх** 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа** 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах** 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх** 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх** 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах** 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох** 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

- | | |
|---|---|
| 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох | 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална. |
| 34. Тендерийг эрэмбэлэх | 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. |
| 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах | 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно. |
- Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
- | | |
|---|--|
| 36. Шийдвэр хүргүүлэх | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| 37. Гүйцэтгэлийн баталгаа | 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана. |
| 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. |

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ),

ТШЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Багачууд Хүнс ОНӨААТУГ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: СБД болон ЧД-ийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлэх хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: БХОНӨААТУГ/20240201029
ТШЗ 1.2	<p>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц 01. Хонины мах нийлүүлэх Багц 02. Ухрийн мах нийлүүлэх Багц 05. Бүх төрлийн гурил худалдан авах Багц 07. Шар будаа худалдан авах Багц 08. Бусад төрлийн будаа худалдан авах Багц 09. Элсэн чихэр худалдан авах Багц 10. Гадаад гоймон худалдан авах Багц 11. Гадаадад үйлдвэрлэгдсэн печень худалдан авах Багц 12. Дотоодод үйлдвэрлэгдсэн печень худалдан авах Багц 14. Байгалийн жимс, жимсгэнэ худалдан авах Багц 16. Цагаан идээ худалдан авах Багц 17. Зөгийн бал худалдан авах Багц 18. Төрөл бурийн чанамал (варень, молоко) худалдан авах Багц 20. Тахианы мах худалдан авах Багц 21. Хүүхдийн будаа худалдан авах Багц 22. Дотоодод үйлдвэрлэгдсэн гоймон худалдан авах Багц тус бүрт худалдан авах бараа, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг уг тендер шалгаруулалтын баримт бичгийн “Бараа нийлүүлэлтийн хуваарь”-т зааж өгөв.</p>
ТШЗ 1.3	<p>Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:</p> <p>Багц 1. Хонины мах нийлүүлэх Багц 2. Ухрийн мах нийлүүлэх Багц 5. Бүх төрлийн гурил худалдан авах Багц 12. Дотоодод үйлдвэрлэгдсэн печень худалдан авах Багц 14. Байгалийн жимс, жимсгэнэ худалдан авах Багц 16. Цагаан идээ худалдан авах Багц 17. Зөгийн бал худалдан авах Багц 22. Дотоодод үйлдвэрлэгдсэн гоймон худалдан авах</p>
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө

ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 831,973,956 <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: right;"> <tbody> <tr><td>1</td><td>Багц-1 Хонины мах нийлүүлэх</td><td>171,986,667</td></tr> <tr><td>2</td><td>Багц-2 Үхрийн мах нийлүүлэх</td><td>388,577,778</td></tr> <tr><td>3</td><td>Багц-5 Бүх төрлийн гурил худалдан авах</td><td>50,968,778</td></tr> <tr><td>4</td><td>Багц-7 Шар будаа худалдан авах</td><td>11,522,222</td></tr> <tr><td>5</td><td>Багц-8 Бусад төрлийн будаа худалдан авах</td><td>26,902,222</td></tr> <tr><td>6</td><td>Багц-9 Элсэн чихэр худалдан авах</td><td>26,000,000</td></tr> <tr><td>7</td><td>Багц-10 Гадаад гоймон худалдан авах</td><td>12,268,611</td></tr> <tr><td>8</td><td>Багц-11 Гадаадад үйлдвэрлэгдсэн печень худалдан авах</td><td>17,023,456</td></tr> <tr><td>9</td><td>Багц-12 Дотоодод үйлдвэрлэгдсэн печень худалдан авах</td><td>23,885,556</td></tr> <tr><td>10</td><td>Багц-14 Байгалийн жимс жимсгэнэ худалдан авах</td><td>36,944,444</td></tr> <tr><td>11</td><td>Багц-16 Цагаан идээ худалдан авах</td><td>19,377,778</td></tr> <tr><td>12</td><td>Багц-17 Зөгийн бал худалдан авах</td><td>5,555,556</td></tr> <tr><td>13</td><td>Багц-18 Төрөл бүрийн чанамал/варень, молоко/ худалдан авах</td><td>9,945,111</td></tr> <tr><td>14</td><td>Багц-20 Тахианы мах худалдан авах</td><td>9,378,889</td></tr> <tr><td>15</td><td>Багц-21 Хүүхдийн будаа мах худалдан авах</td><td>9,888,889</td></tr> <tr><td>16</td><td>Багц-22 Дотоодод үйлдвэрлэсэн гоймон гоймон худалдан авах</td><td>11,748,000</td></tr> <tr> <td></td><td>Нийт дүн</td><td>831,973,956</td></tr> </tbody> </table>	1	Багц-1 Хонины мах нийлүүлэх	171,986,667	2	Багц-2 Үхрийн мах нийлүүлэх	388,577,778	3	Багц-5 Бүх төрлийн гурил худалдан авах	50,968,778	4	Багц-7 Шар будаа худалдан авах	11,522,222	5	Багц-8 Бусад төрлийн будаа худалдан авах	26,902,222	6	Багц-9 Элсэн чихэр худалдан авах	26,000,000	7	Багц-10 Гадаад гоймон худалдан авах	12,268,611	8	Багц-11 Гадаадад үйлдвэрлэгдсэн печень худалдан авах	17,023,456	9	Багц-12 Дотоодод үйлдвэрлэгдсэн печень худалдан авах	23,885,556	10	Багц-14 Байгалийн жимс жимсгэнэ худалдан авах	36,944,444	11	Багц-16 Цагаан идээ худалдан авах	19,377,778	12	Багц-17 Зөгийн бал худалдан авах	5,555,556	13	Багц-18 Төрөл бүрийн чанамал/варень, молоко/ худалдан авах	9,945,111	14	Багц-20 Тахианы мах худалдан авах	9,378,889	15	Багц-21 Хүүхдийн будаа мах худалдан авах	9,888,889	16	Багц-22 Дотоодод үйлдвэрлэсэн гоймон гоймон худалдан авах	11,748,000		Нийт дүн	831,973,956
1	Багц-1 Хонины мах нийлүүлэх	171,986,667																																																		
2	Багц-2 Үхрийн мах нийлүүлэх	388,577,778																																																		
3	Багц-5 Бүх төрлийн гурил худалдан авах	50,968,778																																																		
4	Багц-7 Шар будаа худалдан авах	11,522,222																																																		
5	Багц-8 Бусад төрлийн будаа худалдан авах	26,902,222																																																		
6	Багц-9 Элсэн чихэр худалдан авах	26,000,000																																																		
7	Багц-10 Гадаад гоймон худалдан авах	12,268,611																																																		
8	Багц-11 Гадаадад үйлдвэрлэгдсэн печень худалдан авах	17,023,456																																																		
9	Багц-12 Дотоодод үйлдвэрлэгдсэн печень худалдан авах	23,885,556																																																		
10	Багц-14 Байгалийн жимс жимсгэнэ худалдан авах	36,944,444																																																		
11	Багц-16 Цагаан идээ худалдан авах	19,377,778																																																		
12	Багц-17 Зөгийн бал худалдан авах	5,555,556																																																		
13	Багц-18 Төрөл бүрийн чанамал/варень, молоко/ худалдан авах	9,945,111																																																		
14	Багц-20 Тахианы мах худалдан авах	9,378,889																																																		
15	Багц-21 Хүүхдийн будаа мах худалдан авах	9,888,889																																																		
16	Багц-22 Дотоодод үйлдвэрлэсэн гоймон гоймон худалдан авах	11,748,000																																																		
	Нийт дүн	831,973,956																																																		
	<p>Гэрээ байгуулсны дараа худалдан авах хүнсний бүтээгдэхүүнүүд нь нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэгдэнэ. Техникийн тодорхойлолт, Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ нь тэдгээр байгууллагуудаас жилд дунджаар захиалдаг тоо хэмжээний гүйцэтгэлээр үндэслэн гаргасан тоо хэмжээ болно. Иймээс гэрээ байгуулагdsаны дараа нийлүүлэгчээс худалдан авах барааны тоо хэмжээ нь цэцэрлэг, сургуулиас ирүүлэх захиалгын хэмжээнээс хамаарч зохих хэмжээнд өсөж, буурч болно. Энэ нь нийлүүлэгчтэй байгуулсан бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй бөгөөд гэрээ хэрэгжих явцад гүйцэтгэлийн байдлаас хамаарч гэрээнд заасан барааны нийт тоо хэмжээнд өөрчлөлт орж болохыг мэдэгдье. Захиалсан барааны төлбөрийг гүйцэтгэлээр санхүүжүүлнэ(ГТН-д зааснаар)</p>																																																			
	Б. АГУУЛГА																																																			
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: "Багачууд Хүнс" ОНӨААТУГ</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 13-р хороо Сургуулийн 24-00 тоот өөрийн байранд</p> <p>Утасны дугаар: 11-357813</p> <p>Цахим шуудангийн хаяг: bagachuudhuns@gmail.com</p>																																																			

	<p>Тендериин шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргаж болно.</p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.</p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ <u>Үзүй</u> ”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	<p>Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”</p> <p><i>Гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ.</i></p>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТШЗ 17.4	<p>Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Тийм”</p> <p>Багц 5-аас багц 22 хүртэлх тендерт оролцогч нь тухайн багцын техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцсэн бараа болохыг нотлох зорилгоор нийлүүлэх бүтээгдэхүүн бурийн дээжийг тендер нээх өдрийн 10 цагаас өмнө захиалагчийн ажлын байранд ирүүлнэ (тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэгдсэн хайрцаг, уут, савлагааг хөндөж, задлаагүй бүтэн байдлаар ирүүлнэ. Бүтээгдэхүүний хаяг, шошго харагдах боломжтой байх бөгөөд шалгарсан тохиолдолд нийлүүлэгдэх хэлбэрээр ирүүлж, бүтээгдэхүүний дүр төрх, гадаад байдал бүрэн танигдахаар байна). Шалгалт туршилтыг захиалагч тал өөрөө хийж гүйцэтгэнэ. Дээжийг шалгаж, турших шаардлагатайгаас бусад тохиолдолд буцаан олгож болно.</p>
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “ <u>Үзүй</u> ”
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <p>Тендерт оролцогч нь гэрээ гүйцэтгэх ажилтны боловсон хүчиний мэдээлэл, анкет ирүүлэх.</p> <p>Багц-1, Багц-2, Багц-20-д оролцогч нь малын эмч эсвэл хүнсний эрүүл ахуйч мэргэжлийн үндсэн эсвэл гэрээт ажилтантай байна.</p> <p>Багц 1, 2, 20-д шаардсан ажилтан нь үндсэн эсхүл гэрээт ажилтан болохыг нотлох баримт ирүүлнэ. Тухайн ажилтны мэргэжил эзэмшсэнийг нотлох диплом, түүнтэй адилтгах баримт бичиг(төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системээр дипломын мэдээллийг шалгана), иргэний үнэмлэхийн хуулбар, CV ирүүлэх, 2-оос дээш жил тасралтгүй ажилласан байх,</p>

Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: **“Шаардлагатай”**

2023 онуудын аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх шаардлагатай.

-Оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл, гэрээ, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох бараа нийлүүлсэн, хүлээлцсэн акт эсхүл захиалагчийн тодорхойлолтын хамт ирүүлэх;

- техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 16.1-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох Өгөгдлийн хүснэгтэд заасан бусад баримт.

Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: **“Шаардана”**

1.Эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг нөөцлөн хадгалахад хүрэлцэхүйц багтаамжтай агуулах, байртай байх

- Агуулах, байртайг нотлох баримт ирүүлэх (Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл агуулахын эзэмшигч, өмчлөгчтэй хийсэн түрээсийн гэрээ, хадгалалтын гэрээ, гэрэл зураг, үл хөдлөхийн гэрчилгээний хуулбарын хамт);

2. Эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай бүхээгтэй авто машинтай байх.

- Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай бүхээгтэй авто машинтайг нотлох баримт ирүүлэх (Уг авто машины улсын дугаар нь харагдахуйц гэрэл зургийг ирүүлэх, тээврийн хэрэгсэл нь түрээсийн байх тохиолдолд түрээсийн гэрээ, гэрчилгээ нотлох баримтыг ирүүлнэ. Тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бусад мэдээллийг улсын дугаараар нь tender.gov.mn цахим системээр дамжуулан шалгана)

Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:

Борлуулалтын орлогын хэмжээ: **2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тухайн багцын батлагдсан төсвийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:

1. Байгууллагын дансны баталгаажсан үлдэгдэл /Харилцагч банкны/
 2. Арилжааны банкнаас авч болох зээлийн хэмжээ /Банкны тодорхойлолт/
- Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй байх.**

ТШЗ 18.2	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд тухайн багцад хамаарах үйл ажиллагаа эрхлэх чиглэл тусгасан байна.</p>
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <p>1. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана.</p> <p>Хуулийн дагуу гаргасан 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.</p> <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; - Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт; <p>3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ.</p> <p>Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</p>
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”</p> <p>Мөн дараах баримтыг хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <p>1. Байгууллагын тухай товч танилцуулга ирүүлэх;</p> <p>2. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлэх. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй мэдээллийг шалгана.</p> <p>Нийгмийн даатгалын тодорхойлолтыг цаасаар тендерт хавсаргаж ирүүлнэ.</p> <p>3. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй хүчин төгөлдөр лавлагааг цаасаар авч тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх</p> <p>4. Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх;</p>

	<p>5. Монгол Улсад мөрдөгдөж буй Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн дагуу оролцох багцын бүтээгдэхүүнүүд дээр эрүүл ахуйн шаардлага хангасан тухай итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн ирүүлнэ.</p> <p>Харин багц 1, 2-д оролцогч нь итгэмжлэгдсэн мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний дүн болон мал эмнэлгийн гэрчилгээ (гарал үүслийн гэрчилгээ) ирүүлнэ. Тендерт оролцогч нь бүтээгдэхүүнийг өөрөө үйлдвэрлээгүй тохиолдолд үйлдвэрлэгч эсхүл импортлогч, гэрээт борлуулагчийн шинжилгээний дүнг, эсхүл өөрийн нэр дээр шинжилгээний дүнг гаргуулсан байна.</p> <p>Санал болгох бүтээгдэхүүн тус бүрийг тендер нээх өдрөөс өмнөх 3 сарын дотор дээрх шинжилгээнд хамруулж тендерт хавсарган ирүүлсэн байх шаардлагатай.</p> <p>6. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлэх. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана;</p> <p>7. Тендерт оролцогч нь татвар, банк, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх;</p> <p>8. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх;</p> <p>9. Нийлүүлэх хугацаанд гарсан барааны чанар, үйлдвэрлэгчээс шалтгаалсан аливаа хохирол, доголдлыг туслан гүйцэтгэгч болон гуравдагч этгээдээр дамжуулахгүйгээр шууд үйлдвэрлэгчтэй харилцаж, гарсан асуудлыг өөрийн зардлаар бүрэн шийдвэрлэхийг баталсан албан бичиг ирүүлэх;</p> <p>10. Нийлүүлсэн бараа нь гэмтэлтэй, чанар, эрүүл ахуйн шаардлага хангахгүй тохиолдолд ажлын 2 хоногийн дотор шинэ бүтээгдэхүүнээр сольж өгөхийг зөвшөөрсөн албан мэдэгдэл ирүүлэх;</p> <p>11. Багц 1, 2-д оролцогчийн санал болгох бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолт, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах, турших зорилгоор тендер нээсний дараа хянан үзэх, үнэлэх шатанд тендерт оролцогчийн ажлын байр, агуулахад үнэлгээний хорооны гишүүд очиж бараа, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлтэй танилцах боломжтой талаар албан мэдэгдэл ирүүлэх.</p> <p>12. Дараах эрсдэлүүдийг гүйцэтгэгч хариуцна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүний сав баглаа боодол гэмтсэн • Стандарт шаардлага хангаагүй. • Бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа дуусах дөхсөн /тухайн бүтээгдэхүүний хадгалалтын хугацааны 1/3 хугацаа нь үлдсэн байх/ болон дууссан бол тухайн бүтээгдэхүүнийг солиулах
--	---

	<ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүнийг хүлээн авах үед мэдэгдэх боломжгүй байсан далд гэмтэл зэрэгт доголдлыг арилгуулах, гэмтэл доголдолгүй ижил төрлийн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр солиулах • Бусад <p>Жич: ӨХ-д заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн ӨХ-д шаардагдаагүй үнэлгээнд нөлөөлөхүйц бус баримт бичгийг нэмэлтээр ирүүлсэн тохиолдолд үнэлгээнд харгалзахгүй болно.</p>																																
